

**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА,
ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮНДЭСНИЙ
ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРЛЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

2009 оны 02 дугаар
сарын 09-ны өдөр

Дугаар 73/102

Улаанбаатар
хот

Хамтран ажиллах журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. “Цагдаа, шүүхийн шинжилгээний байгууллагын хамтран ажиллах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Тушаал, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг төв, орон нутгийн цагдаа, шүүхийн шинжилгээний байгууллагын газар, хэлтэс, албаны дарга нарт үүрэг болгосугай.

3. Тушаал, журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлт үр дүнг хагас, бүтэн жилээр танилцуулж байхыг Цагдаагийн ерөнхий газрын Тамгын газар /цагдаагийн хурандаа Ц.Арвинбуудай/, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Тамгын хэлтэс /цагдаагийн хурандаа Ж.Мөнхбаатар/-т тус тус даалгасугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Цагдаагийн ерөнхий газрын дарга, Шүүхийн шинжилгээний үндэсний төвийн захирлын хамтарсан 2006 оны 220/68 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



Цагдаагийн ерөнхий газрын дарга, Шүүхийн
шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирлын
хамтарсан 2009 оны 73/09-р тушаалын хавсралт

ЦАГДАА, ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН ХАМТРАН АЖИЛЛАХ ЖУРАМ

УХГ0025

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Энэ журмын зорилго нь цагдаагийн болон шүүхийн шинжилгээний байгууллагууд гэмт хэрэг илрүүлэх, гэмт этгээдийн үйлдлийг нотлон тогтоох чиглэлээр хэргийн газрын үзлэгийг зохион байгуулж явуулах, хэргийн холбогдолтой ул мөр, эд мөрийн баримт илрүүлж бэхжүүлэх, хураан авах, тэдгээрт шинжилгээ хийж дүгнэлт, магадлагаа гаргах, гэмт хэрэг илрүүлэхтэй холбогдуулан иргэдийн гарын хээний, галт зэвсгийн хонгио ба хошууны, илрээгүй хэргийн ул мөрний, ДНК-ийн гэх мэт нэгдсэн сан бүрдүүлэх, хадгалах, баяжуулах, ашиглах, харилцан мэдээлэл солилцох чиглэлээр хамтран ажиллах харилцааг зохицуулахад оршино.

1.2 Энэ журмыг цагдаа, шүүхийн шинжилгээний бүх шатны нэгж, алба хаагчид дагаж мөрдөнө.

1.3 Энэ журмыг төв, орон нутгийн цагдаа, шүүхийн шинжилгээний газар, хэлтэс, албанд хүргүүлж, нийт бие бүрэлдэхүүнд таниулах, мөрдөж хэвшүүлэх ажлыг Цагдаагийн ерөнхий газрын Тамгын газар, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Тамгын хэлтэс зохион байгуулна.

1.4 Хамтран зохион байгуулах нэгдсэн, тусгайлсан арга хэмжээг урьдчилан тохиролцож тус тусын байгууллагын ажлын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ.

1.5 Талууд мэдээллийн аюулгүй байдлыг хангаж, хойшлуулшгүй шуурхай арга хэмжээний үед цагдаагийн байгууллагын дотоод нэгдсэн сүлжээг ашиглан шаардлагатай мэдээллийг цахим хэлбэрээр солилцоно.

1.6 Онц хүнд гэмт хэрэг үйлдэгдсэн, онцгой нөхцөл байдал үүссэн үед Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн болон тэдгээрийн харъяа нэгжийн дарга нарын хамтарсан тушаалаар ажлын хэсэг байгуулж ажиллуулна.

Хоёр. Байгууллагуудын нийтлэг эрх, үүрэг

2.1 Хамтын ажиллагааны явцад хоёр байгууллагын зүгээс тавьсан асуудлыг тухай бүр удирдлагын хэмжээнд хэлэлцэж шийдвэрлэнэ.

2.2 Харилцан тохиролцсоны үндсэн дээр хойшлуулшгүй ажиллагааны үед төрийн холбооны болон тодорхой дугаар бүхий утсаар мэдээлэл солилцож, шинжилгээний объектыг цагдаагийн байгууллагын тусгай шуудангаар хүргүүлнэ.

2.3 Хамтран ажиллах чиглэлээр ажлын үр бүтээл гаргасан цагдаа, шүүхийн шинжилгээний байгууллагын алба хаагч, ажилтнуудыг харилцан урамшуулж, хариуцлагагүй хандсан ажилтануудад хариуцлага тооцож сахилгын болон бусад арга хэмжээ авах тухай саналаа харъяалах байгууллагын удирдлагад хүргүүлнэ.

2.4 Сэжигтэн, яллагдагч нь тогтоогдоогүй хэргийн ул мөр, эд мөрийн баримт, шинжилгээний объектыг хүргүүлэх, бүртгэж авах, шинжилгээ хийж дүгнэлт гаргах, дүгнэлтийг хүргэх, хэргийн газрын үзлэгээр олдсон гарын хээ, галт зэвсгийн ул мөр, аман зураг гэх мэт шуурхай ажиллагаанд шаардлагатай мэдээллийг шинжилгээний байгууллагаас авах үйл ажиллагааг тусгай журмаар зохицуулна.

2.5 Мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэхтэй холбоотой бусад асуудлыг тус хоёр байгууллагын хооронд байгуулсан гэрээгээр зохицуулна.

Гурав. Цагдаагийн байгууллага, алба хаагчийн эрх, үүрэг

3.1 Нутаг дэвсгэрийн шүүхийн шинжилгээний албыг ажлын байртай болтол ажлын болон лабораторийн өрөөг түрээсгүйгээр ашиглуулах.

3.2 Гэмт хэргийн дуудлага авсан тухай бүр Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн, аймаг, нийслэлийн шүүхийн шинжилгээний албанд шуурхай мэдээлж, хэргийн газрын үзлэг явуулах бүрэлдэхүүнд криминалистикийн мэргэжилтнийг, шаардлагатай бол шүүх шинжээч эмч бусад нарийн мэргэжлийн бүрэлдэхүүнтэй шинжээчдийн хамт оролцуулах арга хэмжээ авах.

3.3 Гэмт хэргийг шуурхай илрүүлэх, эрэн сурвалжлах, хойшлуулшгүй арга хэмжээний хүрээнд иргэдийн гарын хээний нэгдсэн, галт зэвсгийн, ДНК-гийн, хэн болох нь тогтоогдоогүй цогцосны, илрээгүй хэргийн ул мөрний зэрэг мэдээллийн сангуудаас шаардлагатай мэдээллийг гаргуулан авах.

3.4 Гэмт хэрэгт холбогдон шалгагдсан, эрүүлжүүлэгдсэн, баривчлагдсан, захиргааны арга хэмжээ авагдсан иргэдийн гарын хээний дардасыг "Папилон" системийн санд заавал оруулж байх.

3.5 Галт зэвсэг эзэмших эрх хүссэн иргэн болон хуулийн этгээдийн эзэмшилд байгаа галт зэвсгийн сумны хошуу ба хонгиог шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнд хүргүүлж санд бүртгүүлж байх.

3.6 Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгээс галт зэвсгийн төрөл, загварын талаарх дэлгэрэнгүй судалгаа, лавлагааг шинэчлэн авч байх.

3.7 Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгээс галт зэвсэг болон сумны хонгио, хошууны шинжилгээтэй холбогдуулан хүсэлт гаргасан тохиолдолд тухайн галт зэвсэг эзэмшигчийн талаар тодорхой мэдээллийг өгч байх.

3.8 Галт зэвсгийн тухай хууль тогтоомж зөрчиж хураагдсан, гарал үүсэл нь тодорхой бус галт зэвсэг, сум, сумны хошуу, хонгиог шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнд хүргүүлж байх.

Дөрөв. Шүүхийн шинжилгээний байгууллага, ажилтны эрх, үүрэг

4.1 Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн тогтоолоор шинжилгээг үнэ төлбөргүй хийж, дүгнэлтийг тогтоолд заасан хугацаанд шуурхай гаргаж өгөх.

4.2 Их хэмжээний хохиролтой хүнд, онц хүнд гэмт хэргийн газарт төрөл мэргэжлийн бүрэлдэхүүнтэй шинжээч, криминалистикийн мэргэжилтнийг шуурхай оролцуулж байх.

4.3 Хэргийн газрын үзлэгт оролцох криминалистикийн мэргэжилтэнг нутаг дэвсгэрийн цагдаагийн газар, хэлтэс, замын цагдаагийн газар дээр 24 цагаар үүрэг гүйцэтгүүлж байх зохион байгуулалтын арга хэмжээ авах.

4.4 Мэдээллийн санд оруулахаар хүргүүлсэн ул мөрийг бүртгэсний дараа хэргийн дугаар бүхий тусгай тэмдэгтээр буцаан хүргүүлж байх.

4.5 Шинжээч нь шинжилгээ хийх явцдаа олж мэдсэн гэмт хэргийн талаарх шинэ мэдээ, мэдээллийг цагдаагийн байгууллагад нэн даруй мэдэгдэж, хамтран ажиллах.

4.6 Цагдаагийн байгууллагаас гаргасан хүсэлтийн дагуу иргэдийн гарын хээний, галт зэвсгийн хонгио ба хошууны, хэн болох нь тогтоогдоогүй цогцосны, дүр зургийн, ДНК-гийн зэрэг мэдээллийн сангаас хэргийн холбогдолтой мэдээллийг шуурхай гарган өгч байх.

4.7 Хураагдсан буюу олдсон галт зэвсгийн сумны хошуу, хонгиог санд оруулж, аюулгүй байдлыг ханган, тухай бүр албан бичгийн хамт цагдаагийн байгууллагад буцааж хүргүүлэх.

4.8 Галт зэвсгийн сумны хошуу, хонгионы сангийн баяжилтийн тайлан мэдээг Цагдаагийн ерөнхий газрын Нийгмийн хэв журам хамгаалах газарт улирал тутам хүргүүлэх.

4.9 Цагдаагийн байгууллагын ажлын байранд үүрэг гүйцэтгэж байх үед тухайн байгууллагын дотоод журмыг чанд мөрдөж байх.

4.10 Нутаг дэвсгэрийн цагдаагийн газар, хэлтэс, замын цагдаагийн газар дээр 24 цагаар үүрэг гүйцэтгэж байгаа криминалистикийн мэргэжилтэн нь жижүүрийн бүрэлдэхүүнд ажиллаж буй алба хаагчдын нэгэн адил тухайн байгууллагын дарга, эрүү, мөрдөн байцаах албаны хэлтэс, тасгийн дарга, хариуцлагатай зохицуулагч, жижүүрийн офицерийн удирдлага дор цагдаагийн байгууллагын албаны шуурхай байдлыг хангаж ажиллах.

4.11 Гарын хээ авах ажлыг тухайн цагдаагийн газар, хэлтэс дээр гүйцэтгэж байх.

Тав. Бусад

5.1 Тус хоёр байгууллагын шат шатны дарга нар сар тутам ажил хэргийн уулзалт хийж, энэ журмын хэрэгжилтийн явц байдал, үр дүнгийн талаар харилцан мэдээ, мэдээлэл солилцож, цаашид анхаарах асуудлын чиглэлийг гарган хэрэгжүүлж, үр дүнг тооцож байна.

5.2 Энэ журмыг зөрчсөн буруутай алба хаагчид холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ
ГАЗАР

ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮНДЭСНИЙ
ХҮРЭЭЛЭН